



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/2024

Улаанбаатар хот

Хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Нийслэлд төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 3 дугаар хавсралтын 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид 2024 оны 12 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдах Багахангай, Налайх, Багануур дүүргийн хороодын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтад 1, 2 дугаар хорооны Засаг дарга нарыг оролцуулахыг Цэргийн штаб (Хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2.Хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтад оролцох албан тушаалтны нэрийн жагсаалтыг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шаардагдах зардал 598,650 (Таван зуун ерэн найман мянга зургаан зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны ... дүгээр сарын ... ны өдрийн ... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА НАРЫН ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ
СУРГАЛТАД ОРОЛЦОХ АЛБАН ТУШААЛТНЫ НЭРИЙН ЖАГСААЛТ

д/д	Албан тушаал	Цол	Овог	Нэр
1	Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга	Хурандаа	Шоовдор	Бат-Өлзий
2	Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Тоо бүртгэл дайчилгааны ахлах офицер	Дэд хурандаа	Алтангэрэл	Баярбат
3	1 дүгээр хорооны Засаг дарга	Энгийн	Наваан	Нямзав
4	2 дугаар хорооны Засаг дарга	Энгийн	Батбаяр	Батзориг

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 2 дүгээр сарын 22 ны өдрийн 10 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



СУРГАЛТ ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Маршрут	Машины марк	Цэргийн штаб, Хороон Засаг дарга	Нийт км	Зарцуулах шатахуун	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
Суудлын авто машин Зарцуулах шатахуун (100 км-т 18 л хийн түлш)							
2	Багахангай дүүргээс Зэвсэгт хүчний 014 дүгээр анги, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангиас Багахангай дүүрэг	SONATA-7	4	150 км	27 л	1950	52,650
Бүгд			4	150 км	27 л	1950	52,650

СУРГАЛТ ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ БИЧИГ ХЭРЭГ, ХҮНСНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Хоолны төрөл	Нэг бүрийн үнэ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өглөө, өдөр (I, II хоол) оройн хоол талх цай	3 хоног (4 хүн өдөр)	35,000 x 4 x 3 = 420,000	420,000
2	Ажлын дэвтэр	4	19,000	76,000
3	Гэрчилгээ	2	25,000	50,000
бүгд				546,000
нийт				598,650